

Зарим тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Хорооны 2007 оны 193 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-ын 2.3.3-т дор дурдсан хэсгийг нэмсүгэй:

1/ “бизнесийн цар хүрээ нь тогтворжсон байх” гэж даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч нь Монгол Улсад 1 жилээс доошгүй хугацаанд үйл ажиллагаагаа тогтвортой явуулсан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улирал тутам санхүүгийн тайлангаа харилцагч санхүүгийн байгууллагад тогтмол тушааж байсан байх, сүүлийн 2 улирлын санхүүгийн тайлан тэнцэл нь алдагдалтай гараагүй байхыг ойлгоно.

2.Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 2 дугаар бүлгийн Б хэсэгт дор дурдсан хэсгийг нэмсүгэй:

1/ Давхар даатгалын компанийн алдагдлаас хамгаалах сан нь 5 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээтэй байна. Энэхүү хэмжээг Хороо давхар даатгалын үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээнээс хамааран нэмэгдүүлэн тогтоож болно. Сангийн мөнгөн хөрөнгийн зарцуулалт, зохицуулалттай холбоотой журмыг Хороо батална.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ